



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2011 оны 2 сарын 22 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Г Дархлаажуулалтын зөвлөх хорооны
дүрмийг шинэчлэх тухай

Дархлаажуулалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зорилгоор ТУШААХ НЬ:

1. Дархлаажуулалтын зөвлөх хорооны шинэчилсэн дүрмийг нэгдүгээр, зөвлөх хорооны гишүүдийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Дархлаажуулалтын зөвлөх хорооны үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн жил бүрийн төсөвт тусгаж байхыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Н.Түмэндэмбэрэл), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 201 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.



С.ЛАМБАА



Эрүүл мэндийн сайдын 2011 оны 23.р сарын 23-ны
өдрийн 55 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Дархлаажуулалтын зөвлөх хорооны дүрэм

Нэг. Ерөнхий зүйл

Сүүлийн жилүүдэд дархлаажуулалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын хамралтын хүрээ тэлж, шинэ болон хавсарсан вакциныг дархлаажуултад нэвтрүүлж байгаатай холбогдуулан нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үүднээс ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу дэлхийн олон орнууд ялангуяа хөгжиж буй орнууд бие даасан дархлаажуулалтын зөвлөх хороо байгуулах болсон юм.

Дархлаажуулалтын зөвлөх хороо (ДЗХ) нь дархлаажуулалтын талаар Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах үндсэн үүрэг бүхий бие даасан бүтэц байна.

ДЗХ-ны бүрэлдхүүнийг энэ дүрмийн З дугаар зүйлд заасны дагуу Эрүүл мэндийн сайд томилно.

Хоёр. Дархлаажуулалтын зөвлөх хорооны үүрэг

2.1. Дархлаажуулалтын бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэд дүгнэлт гаргах, боловсронгуй болгох талаар санал боловсруулах.

2.2. Дархлаажуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх урт, богино хугацааны хөтөлбөр, стратегид зөвлөгөө өгөх.

2.3. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтийг боловсруулахад нь холбогдох байгууллага, албадад зөвлөгөө өгөх.

2.4. Дархлаажуулалттай холбогдсон шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл цуглуулах, холбогдох байгууллага албадад зөвлөгөө өгөх.

2.5. Дархлаажуулалтын болон шинэ вакцин хэрэглэх технологийн бодлого боловсруулахад нь холбогдох байгууллагуудад зөвлөгөө өгөх.

2.6. Дархлаажуулалтын үйл ажиллагааг тогтвортой, шинжлэх ухааны үндэслэлтэй байлгах талаар Засгийн газрын болон олон улсын байгууллагууд,

иргэний нийгэм, үйлдвэрлэгч, хандивлагч нарын хамтын ажиллагааг сайжруулахад нь туслах.

Гурав. Дархлаажуулалтын зөвлөх хорооны бүрэлдэхүүн

3.1. Дархлаажуулалтын зөвлөх хороо нь таслах эрхтэй 11 гишүүн, таслах эрхгүй 9 гишүүнтэй байна. ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын алба ДЗХ-ны ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.

3.2. ДЗХ-ны дарга нь Эрүүл мэндийн дэд сайд байна.

3.3. ДЗХ-ны ажлын албаны дарга нь тус хорооны нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

3.4. ДЗХ-ны таслах эрхтэй 11 гишүүн нь Монголын Анагаах ухааны академи, мэргэжлийн холбоодоос санал болгосон тархвар судлаач, хүүхдийн эмч, халдвартын эмч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эрүүл мэндийн эдийн засагч, дархлаа судлаач, биотехнологич, микробиологич, дархлаажуулалтын үндэсний хөтөлбөрийн зохицуулагч зэрэг нарийн мэргэжлийн эрдэмтэн судлаачид байна.

3.5. Монголын Анагаах ухааны академи, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллагуудын монгол дахь төлөөлөгчийн газрууд нь мэргэжлийн буюу эрдмийн зэрэг цолтой, дархлаажуулалтын асуудлаар олонд танигдсан, эсвэл уг асуудлыг хариуцсан нэр хүндтэй мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачийг хэлэлцэж, нэг суудалд хоёроос доошгүй хүний нэр дэвшүүлж ХӨСҮТ-д ирүүлнэ.

3.6. ДЗХ-ны таслах эрхгүй гишүүд нь дархлаажуулалтын үйл ажиллагаатай холбоотой байгууллагыг төлөөлөн оролцох эрх бүхий мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачид байна.

3.7. ДЗХ-ны таслах эрхтэй гишүүд нь хуралдаанаараа таслах эрхгүй гишүүдийн нэрийг дэвшүүлэн хэлэлцүүлнэ.

3.8. ДЗХ-ны таслах эрхтэй гишүүдийг 3 жилийн хугацаатай томилно.

3.9. ДЗХ-ны таслах эрхтэй гишүүдийг дахин нэг удаа улируулан сонгож болно.

3.10. ДЗХ-ны таслах эрхгүй гишүүдийг 3 жилийн хугацаанд томилох ба тухайн байгууллагад ажиллахаа болиход гишүүнчлэл нь цуцлагдана.

3.11. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор ДЗХ-ны хуралдаанд 5 хүртэлх мэргэжилтнийг урьж ажиглагчаар оролцуулж болно.

3.12. Дархлаажуулалтын талаар хамтран ажилладаг олон улсын байгууллага, олон улсын төрийн бус байгууллагуудаас 5 хүртэлх мэргэжилтнийг ажиглагчаар урьж оролцуулж болно.

3.13. ДЗХ-ны гишүүнийг хүндэтгэх шалтгаангүйгээр дараалан 2-оос дээш хуралд оролцоогүй, ашиг сонирхлын зөрчилтэй, мэргэжлийн шаардлагыг хангаагүй, ёс зүйн зөрчил гаргасан зэрэг тохиолдолд чөлөөлнэ.

Дөрөв. Дархлаажуулалтын зөвлөх хорооны хуралдааны дэг,
шийдвэр гаргах

4.1. Дархлаажуулалтын зөвлөх хороо нь улирал тутам хуралдана. Хорооны хурлаар батлагдсан хэлэлцэх асуудлын төлөвлөгөөтэй байна. Хорооны дарга шаардлагатай үед ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

4.2. ДЗХ-ны хурлын хэлэлцэх асуудал, хөтөлбөр, холбогдох материалыг 7 хоногийн өмнө гишүүдэд хүргүүлсэн байна.

4.3. ДЗХ-ны гишүүн хэлэлцэх асуудлыг санаачилж болно.

4.4. Тусгай шаардлага гараагүй тохиолдолд хурлыг нээлттэй хийнэ.

4.5. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хариуцаж байгаа байгууллагын төлөөлөгчийг оролцуулж болно.

4.6. Хэлэлцэх асуудалтай холбоотой хэвлэлийн тойм, мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийх, хурлаас гарах шийдвэрийн төсөл бэлтгэх зэрэг ажлыг хорооны ажлын алба гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд хэлэлцэх асуудалтай холбогдуулан судалгаа, шинжилгээний ажлыг хорооны гишүүнээр ахлуулсан баг байгуулан гүйцэтгүүлж болно.

4.7. ДЗХ-ны таслах эрхтэй гишүүдээс ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг тусгай батлагдсан асуумжийн дагуу жилд 1 удаа ажлын алба авна. Мөн таслах эрхтэй гишүүн нь хуралдаан бүрийн өмнө хэлэлцэх асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухайгаа хорооны даргад мэдэгдсэний дараа дарга хуралдаанд оролцох эсэхийг шийдвэрлэнэ. Энэ тухай хурлын тэмдэглэлд бичсэн байна.

4.8. ДЗХ-ны гишүүд 70%-ийн ирцтэй оролцсон хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.

4.9. ДЗХ-ны хурлын шийдвэрийг дийлэнх олонхийн саналаар гаргана.

- 4.10. ДЗХ-ны хурлын шийдвэрийг хурал даргалагчийн гарын үсгээр баталгаажуулна.
- 4.11. ДЗХ-ны хурлаас гарсан шийдвэрийг ажлын З хоногийн дотор баталгаажуулж Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.
- 4.12. ДЗХ-ны хурлын тухай мэдээлэл, гаргасан зөвлөмжийг нарийн бичгийн дарга бэлтгэж, ЭМЯ, ХӨСҮТ-ийн вэб сайтад тавина.

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 2 сарын 28-ны
өдрийн 55 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Дархлаажуулалтын зөвлөх хорооны гишүүд

Нэг.ДЗХ-ны Таслах эрхтэй гишүүд

1. Ж.Цолмон, Эрүүл мэндийн дэд сайд
2. П.Нямдаваа, Вирус судлаач, Академич, ШУ-ны доктор, профессор
3. Б.Баярт, Дархлаа судлаач, ШУ-ны доктор
4. Н.Жаргалсайхан, Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн, ШУ-ны доктор
5. Д.Нарангэрэл, Дархлаажуулалтын хөтөлбөрийн үндэсний зохицуулагч
6. Н.Цэнд, Тархвар судлаач, АУ-ны доктор,
7. С.Мөнхбаярлах, Эмгэг физиологи, харшил судлаач, АУ-ны доктор, дэд профессор
8. Л.Ундрям, Эрүүл мэндийн эдийн засагч,
9. Д.Рэгзэдмаа, Микробиологч, Клиникийн профессор, тэргүүлэх зэргийн эмч
10. М.Алтанхуяг, Өрхийн эмч
11. Б. Мөнхтуул, Эдийн засагч

Хоёр.ДЗХ-ны Таслах эрхгүй гишүүд

1. С.Төгсдэлгэр, Эрүүл мэндийн яам
2. Ш.Энхтөр, Эх нялхсын эрдэм шинжилгээний төв
3. Г.Сүрэнханд, Халдварт өвчин судлалын үндэсний төв
4. Ж.Оюунбилэг, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн
5. Т. Ариунтуяа, ЗГХА-Эрүүл мэндийн газар
6. Г. Цэндээхүү, Улсын мэргэжлийн хяналтын газар
7. З.Адъясүрэн, Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төв
8. О.Дамба, Эм зүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" холбоо
9. Б.Мөнхбат, Анагаах ухааны хүрээлэн